

Өвөр монголын морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийг судалсан зарим үр дүн

^aБ.Оргил*, ^бТ.Батболд

^aӨвөр Монголын Үндэстний Их Сургууль,

Дуу хөгжмийн сургууль, Ардын Хөгжмийн тэнхим

^бМонгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Судалгааны арга зүйн тэнхим

Хураангуй

Морин хуур нь монгол үндэстний уламжлалт хүндэтгэн дээдэлдэг хөгжмийн нэг бөгөөд сүүлийн жилүүдэд Өвөр Монголд хурдацтай хөгжиж байна. Морин хуур хөгжмийн сургалтууд олноор бий болж байгаа энэ үед морин хуурыг зааж сургах багшийн мэргэжлийн хөгжлийг судалж зохих дүгнэлт өгөх зайлшгүй шаардлага тулгараад байна. Морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийг судлахын тулд 60 багшаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулж судалгааны үр дүнг боловсруулав. Багшийн мэргэжлийн хөгжлийг тодорхойлохын тулд олон талаас нь авч үзэх шаардлагатай бөгөөд энэхүү судалгаанд морин хуурын багшийн ерөнхий мэдээллээс эхлээд мэргэжлийн хөгжилд нөлөө үзүүлэгч эерэг болон сөрөг хүчин зүйлс, түүнийг тодорхойлдог элементүүд, өнөөгийн байдал болон цаашид хөгжүүлэх боломж бололцоо, багш өөрийн мэргэжлийг хөгжүүлэхийн тулд хэрхэн сургалт, семинар, уралдаан тэмцээн, хурал зөвлөгөөнд оролцож буй байдал зэргийг тодруулж дүгнэлт хийсэн. Судалгааны үр дүнд Өвөр Монголын морин хуурын багш нарын мэргэжлийн хөгжлийн түвшин дундаж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах шаардлагатай, мэргэжлийн хөгжилд удирдлагын дэмжлэг, санхүүгийн боломж, ажлын ачаалал гол нөлөө үзүүлдэг, цаашид багш нар мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх, заах ур чадвараа сайжруулах, олон аяыг тоглож сурах сонирхолтой гэж гарсан.

Түлхүүр үг

Багшийн хөгжил, сургалт, хөгжлийн түвшин, мэргэжлийн ур чадвар, саад бэрхшээл, мэдлэг, хэрэгцээ

Удиртгал

Морин хуур хөгжмийн багш нарын өнөөгийн чадавх, эзэмшсэн мэргэжлийн онол болон практикийн зөрүүг тодорхойлж чадсанаар хойч үедээ үндэсний өв уламжлалаа сэргээн хөгжүүлэх, тасралтгүй хөгжих боломжийг бий болгож энэ нь урт хугацаанд улс орны хөгжил, ард түмний оюун санаа соён гэгээрэх үйл явцад томоохон хувь нэмрээ оруулах юм.

Тус судалгаа нь Өвөр Монголын морин хуур хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийн түвшинг тодорхойлж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх, багшийн хэрэгцээ шаардлагыг тодруулах зорилготой. Өвөр Монголын морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийн өнөөгийн байдлыг зарим талаар судалж, морин хуур хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийг судалж, зохих санал дүгнэлт өгөх зорилт дэвшүүлсэн.

Судлагдсан байдал

Судлаачдын дэвшүүлсэн багшийн хөгжлийн талаарх онол, үзэл баримтлалыг асуудлууд нэлээдгүй судлагдсан байна.

Багшийн хөгжлийн асуудлыг эрдэмтэд 1990-ээд оноос чухалчлахдаа юуны өмнө заадаг хичээлийн талаарх мэдлэгийг нэн тэргүүнд тавьж улмаар багшлах ур чадварыг авч үзэж байсан бол хожим нь багшлах явцдаа суралцах зарчмаар багшийн мэргэжлийн хөгжлийг тайлбарлах хандлага давамгайлсан.

Тухайлбал, Данийн Вангийн Их Сургуулийн профессор Жонни Бальтерсон “Багшийн хөгжих үйл явц насан туршийнх бөгөөд үйл ажиллагаанаасаа сурч туршлагажин хөгжиж байдаг, багш хөгжих олон арга зам байдаг ч тэдгээрийн дотор өөрөө өөрийгөө хөгжүүлэх шиг үр дүнг тэр дор нь мэдэрдэг арга зам ховор байдаг, сургалтын үйл явцад багш өөрийгөө судлах аргад суралцах, өөрийгөө судалснаар хөгжлийн хэрэгцээгээ мэдэрнэ, боловсролын хөгжлийн хоцрогдлыг арилгах нэг тулгуур нь багшийн хөгжил” гэж үзжээ.

Ч.Байгалмаа “Багш Мэргэжлийн Практик Үйл Ажиллагаандаа Тулгуурлан Хөгжих Явцын Судалгаа” нэг сэдэвт бүтээлд багш өөрийн мэргэжлийн практик үйл ажиллагааны явцад хэрхэн хөгжих боломжтойг туршин судалж, үр

*Холбоо барих зохиогч: mdaorigele2019@qq.com

дүнг илрүүлэн мэргэжлийн тогтвортой хөгжлийг хангах үр ашигтай хувилбар боловсруулсан байна (Байгалмаа, 2009)

Багшийн өөртөө итгэх итгэл, үр нөлөөтэй байдал нь багшлах ажлын сэдэлд суурилсан түүнийг тасралтгүй сайжруулах цогц чадвараар илэрхийлэгдэнэ. Харин нийгмийн нөхцөл байдал, орчны нөлөөлөл нь багшлах үйл ажиллагаанаас хамт ажиллагчид, эцэг эхчүүд, суралцагчдын хүлээлттэй холбоотой тайлбарлагдана. Багшийн хөгжилтэй холбоотой эдгээр гурван бүрдэл нь бүхэлдээ сургалтын үйл ажиллагааны хүрээнд хамаарах ойлголт гэж тодорхойлсон байна (Бэгз, Санжаабадам, 2015, х.6).

Хятадын судлаач Юүэ Зүан Зүан⁴⁰ “Их Сургуулийн багшийн Мэргэжлийн хөгжлийн Экологийн Загварыг Судалсан” нэг сэдэвт бүтээлд экологийн шинэ үзэл баримтлалаас Цэргийн анагаах ухааны дээд сургуулиудад багш нарын мэргэжлийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан, цэргийн мэргэжлийн их сургуулиудад багш нарын мэргэжлийн хөгжлийн экологийн загварыг бий болгох, багшийн мэргэжлийн хөгжлийн өнөөгийн байдлыг судалж, багшийн мэргэжлийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэн, хөгжлийн практик арга замыг хайж, онолын судалгааны тогтолцоог сайжруулсан байна (Юүэ Зүан Зүан, 2013, х.68).

Судлаач Гао Юан Юан⁴¹ “Сургалтын Шинэчлэлийн Талаарх Бага Сургуулийн Дүрслэх Урлагийн Багшийн Мэргэжлийн Хөгжлийн Судалгаа” нэг сэдэвт бүтээлд хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд Өвөр Монголын “Т” хотын бага сургуулийн дүрслэх урлагийн багш нарын мэргэжлийн хөгжлийн өнөөгийн байдлыг илрүүлэн, бага сургуулийн дүрслэх урлагийн багш нарын мэргэжлийн хөгжлийн шинэ шаардлагыг тодотгосон байна (Гао Юан Юан, 2014, х.30).

Судлаач Жан Шио Лин⁴² “Австралийн TAFE⁴³ Багшийн Мэргэжил Хөгжилд хийсэн судалгаа” нэг сэдэвт бүтээлээс харахад Австралийн TAFE багш мэргэжлийн хөгжлийн туршлага, TAFE багшийн мэргэжлийн хөгжлийн түүх, статусын квот болон түүний туршлагын цогц системчилсэн судалгаа хийсэн байна (Жан Шио Лин, 2017, х.27)

Багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх дээр дурдсан онол, үзэл санаанд тулгуурлан морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийг тодорхойлбол, энэ нь хөгжмийн онол болон багшлахуйн онолын шинжлэх ухааны мэдлэгээ

дээшлүүлэх, хөгжимдөх болон заах ур чадвараа нэмэгдүүлэх, хөгжмийн мэдрэмж авьяасыг нээн илрүүлэх, эерэг хандлагыг өөрт төлөвшүүлэх, монгол үндэстний соёл уламжлалыг дээдлэн хүндэтгэх байдлаар өөрийн мэргэжлийг тал бүрээс нь хөгжүүлэх үйл явц гэж үзэх боломжтой. Гэтэл морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийг нарийвчилсан судалгаа төдийлөн хийгдэхгүй байна.

Судалгааны арга зүй

Судалгааны ажилд Өвөр Монгол, Монгол улс болон бусад улс орнуудад морин хуур, багшийн мэргэжлийн хөгжлийн талаар бичигдсэн ном бүтээлүүдийг баримтын шинжилгээний аргаар боловсруулсан. Өвөр монголын морин хуур мэргэжлийн 60 багшаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулж үр дүнг Microsoft Excel 2010, SPSS 22.0 программ дээр боловсруулав. Судалгааны асуултуудыг боловсруулахдаа багшийн мэргэжлийн хөгжлийн онолд тулгуурласан. Тухайлбал, багшийн онолын мэдлэг, заах ур чадвар, хандлага, үнэт зүйл зэрэгт тулгуурлан асуулгын хуудас боловсруулсан.

Судалгааны үр дүн

Дээрх тодорхойлолтод үндэслэн морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийг судлах 20 асуултаас бүрдэх асуулгыг боловсруулсан бөгөөд Өвөр монголын 8 аймгийн 60 морин хуурын багшийг судалгаанд хамруулж үр дүнг статистик боловсруулалтаар харуулсан болно.

Өвөр Монголын морин хуур хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийг тодорхойлох, түүнд нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор Өвөр Монголын морин хуурын 60 багшийг судалгаанд хамруулсан. Судалгааны мэдээллийг SPSS программ дээр боловсруулж дараах үр дүнд хүрсэн болно.

Хүснэгт 1

Найдвартай байдлын үзүүлэлт

Cronbach's Alpha	Асуултын тоо
0.64	10

Боловсруулсан асуулгын хуудас нь нийт 20 асуулттай бөгөөд ерөнхий мэдээллийг агуулсан 10, үндсэн мэдээллийг агуулсан 10 асуултаас тус тус бүрдэнэ. Иймд үндсэн 10 асуулт нь боловсруулалтын хувьд нэгэн бүлэгт багтаж байгаа эсэхийг мэдэхийн тулд SPSS программ дээр найдварын байдлын шалгуур болох

⁴⁰岳娟娟

⁴¹高妍彦

⁴²张晓玲

⁴³Technological And Further Education

Cronbach's Alpha тооцож үзэхэд 0.64 гарсан тул 0.7-д ойрхон буюу зохистой хязгаарт байгаа нь батлагдсан (Хүснэгт 1).

Хүснэгт 2

Статистикийн суурь утга

	N	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга	Стандарт хазайлт
Таны нас	60	24	45	31.6	5.6

Судалгаанд хамрагдагчдын насны үзүүлэлт нь хэмжээст хувьсагч тул статистикийн суурь утга тооцох боломжтой гэж үзээд үүнийг тооцож үзэхэд судалгаанд хамрагдагчдын тоо 60, хамгийн бага настай нь 24, хамгийн өндөр настай нь 45, дундаж нас 31.6, дундаж наснаас хэлбэлзэх утга 5.6 гарсан тул алдаа бага байна (Хүснэгт 2).

Хүснэгт 3

Хүйсийн давтамжийн утга

Хүйс	Давтамж	Эзлэх хувь
Эрэгтэй	44	73.3%
Эмэгтэй	16	26.7%
Нийт	60	100%

Судалгаанд хамрагдсан морин хуурын багш нарыг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй 44 багш буюу 73.3%, эмэгтэй 16 багш буюу 26.7%-ийг тус тус эзэлж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 4

Багшийн албан тушаалын давтамжийн утга

Албан тушаал	Давтамж	Эзлэх хувь
Сургалтын төвд багш	10	16.7%
Дунд сургуульд багш	23	38.3%
Коллежид багш	22	36.7%
Их дээд сургуульд багш	5	8.3%
Нийт	60	100%

Багш нарын албан тушаалыг авч үзвэл дунд сургууль болон коллежид хамгийн их буюу 22-23 багш ажилладаг бөгөөд судалгаанд хамрагдсан багш нарын 75%-ийг эзэлж байна. Харин сургалтын төвд 10 багш ажилладаг буюу 16.7%, хамгийн бага буюу их дээд сургуульд 5 багш ажилладаг байна (Хүснэгт 4).

Хүснэгт 5


Багшийн мэргэжлээр ажилласан жилийн давтамжийн утга

Ажилласан жил	Давтамж	Эзлэх хувь
1-5	30	50%
6-10	23	38.3%
11-15	6	10%
16-20	1	1.7%
Нийт	60	100%

Морин хуурын багш нарын ажлын туршлагыг судалж үзвэл 1-5 жил ажилласан буюу харьцангуй залуу багш нар судалгаанд оролцогчдын 50%-ийг эзэлж байна. Харин 6-10 жил ажилласан багш нар 38.3%, 11-ээс дээш жил ажилласан багш нар 11.7%-ийг тус тус эзэлж байна. Судалгаанд оролцогчид морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх үндсэн асуултад дараах хариултыг өгсөн.

График 1


Морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийн түвшин



Зургаас харахад багш нарын 15% нь морин хуур хөгжмийн мэргэжлийн өндөр түвшинд, харин 25% нь доогуур түвшинд, 60% нь дундаж түвшинд байна. Энэ нь цаашид мэргэжлийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. Сүүлийн 5 жилд мэргэжлээ дээшлүүлэх сургалт, мэргэжлийн хурал, мэргэжлээрээ уралдаан тэмцээнд оролцож өөрийгөө хөгжүүлсэн байдлыг судалж үзэн Зураг 2-оор үр дүнг илэрхийллээ.

График 2

Морин хуурын багшийн мэргэжлээ дээшлүүлсэн байдал




Морин хуур хөгжмийн мэргэжлийн багш нар сүүлийн 5 жилд мэргэжлийн хурал зөвлөгөөнд олноор оролцсон бөгөөд харин мэргэжлийн уралдаан тэмцээнд дунд зэрэг оролцсон. Мэргэжлээ дээшлүүлэх сургалтад цөөн удаа хамрагдсан нь багш нарын мэргэжлийн талын хөгжлийг дэмжих шаардлагатай нь харагдаж байна.

Мэргэжлээ хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг авч үзэхэд хамгийн олон багш нар удирдлагын дэмжлэг, санхүүгийн боломж, ажлын ачаалалтай холбоотой гэж үзсэн.

График 3

Мэргэжлээ хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл




Энэ нь цаашид морин хуур хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжилд удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлж санхүүгийн боломжоор хангах, мөн ажлын ачааллыг бууруулах хэрэгтэйг харуулж байна.

Багш нарын хувьд өөрийн мэргэжлийг хөгжүүлэх боломж байна гэж 80 гаруй хувь нь хариулсан. Энэ нь тэдний хувьд мэргэжлийн хөгжил чухал бөгөөд сонирхол байгааг баталж байна.

График 4


Цаашид өөрийн мэргэжлийг хөгжүүлэх боломж



Судалгаанд оролцогч багш нар морин хуур мэргэжлийг цаашид мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх, заах ур чадвараа сайжруулах, олон аяыг тоглож сурахыг илүүд үзэж байна.

График 5

Цаашид мэргэжлээ хөгжүүлэх чиглэл




Эндээс дүгнэхэд багш нар онолын мэдлэгээ сайжруулах гэхээсээ илүү бодит ур чадварыг хөгжүүлэхийг хүсэж байгаа нь харагдаж байна.

Морин хуур хөгжмийн багш нар өөрийн мэргэжлийн хөгжлийг дундаж түвшинд байна гэж үнэлсэн бөгөөд энэ нь цаашид хөгжүүлэх хэрэгцээ байгааг нотолж байна.

График 6

Морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийн өөрийн үнэлгээ



Морин хуурын багшийн мэргэжлийн хөгжлийн талаар өөрийн үзэл бодлоо бичих нээлттэй асуулт асууж өгсөн хариултыг нэгтгэж үзвэл удирдлагаас дэмжлэг үзүүлэх, ажлын ачаалал их байна, мэргэжлийн сургалт, хурал, уралдаан тэмцээнийг илүү их зохион байгуулах, мэргэжилдээ дуртай байх, заах арга барилд өөрчлөлт шинэчлэлт хийх, шинэ мэдлэг эзэмших, багшийн хөгжлийн асуудлыг хүндэтгэн үзэх, багшийн онолын мэдлэг дутмаг, морин хуурын багшийн судалгааны чадвар сул, багшлах чадвар тааруу, багш ажлын байрандаа тасралтгүй суралцах орчинг бүрдүүлэх, сургууль болон нийгмийн зүгээс морин хуурын сургалтыг сурталчлан таниулах, морин хуурын хичээлийг заах сурах бичиг боловсруулах, морин хуурын багшийг үнэлэх баримжаатай болох, өөрийн мэргэжилдээ үнэнч тууштай хандах, уламжлалт арга барилыг сэргээн хөгжүүлэх, морин хуурын сургалтыг эмх цэгцтэй, дэс дараалал сайтай зохион байгуулах зэрэг хариултыг өгчээ.

Дүгнэлт

Харин үндсэн мэдээллийг нэгтгэж дүгнэвэл Өвөр Монголын морин хуур хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийн түвшин ерөнхийдөө дундаж байгаа нь цаашид хөгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах шаардлагатай юм. Харин мэргэжлийн хөгжилд гол нөлөө үзүүлэгч хүчин зүйлс нь удирдлагын дэмжлэг, санхүүгийн боломж, ажлын ачаалал бөгөөд цаашид багш нар мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх, заах ур чадвараа сайжруулах, олон аяыг тоглож сурах сонирхолтой байна. Багш нарын өөрийн үнэлгээгээр морин хуур хөгжмийн мэргэжлийг хөгжүүлэх бүрэн боломж байна гэж үзсэн. Мөн багшийн заах арга барилд шинэчлэл хийх, онолын мэдлэгийг дээшлүүлэх, судалгааны чадварыг нэмэгдүүлэх, сурах бичиг боловсруулах, морин хуурын багшийг үнэлэх баримжаатай болох, өөрийн мэргэжилдээ үнэнч тууштай хандах, уламжлалт арга барилыг сэргээн хөгжүүлэх шаардлагатай юм.

Ном зүй

- Байгалмаа, Ч. (2009). *Багш мэргэжлийн практик үйл ажиллагаандаа тулгуурлан хөгжих явцын судалгаа*. Улаанбаатар
- Бэгз, Н., Санжаабадам, С. (2015). Сайн багш-Багшийн хөгжил. *Боловсрол судлал сэтгүүл*, №08. Улаанбаатар.
- Гао Юан Юан. (2014). *Сургалтын Шинэчлэлийн Талаарх Бага Сургуулийн Дүрслэх Урлагийн Багшийн Мэргэжлийн Хөгжлийн Судалгаа*
- Юүэ Зүан Зүан. (2013). *Их Сургуулийн багшийн Мэргэжлийн хөгжлийн Экологийн Загварыг Судалсан*.
- Жан Шио Лин. (2017). *Австралийн TAFE Багшийн Мэргэжил Хөгжилд Хийсэн Судалгаа*.

Some findings of the Study on the Professional Development of Morin Khuur teachers in Inner Mongolia

^aAorigele*, ^bBatbold.T

^aDepartment of Instrumental music, conservatory of music, Inner Mongolia University for Nationalities

^bDepartment of research methodology, School of educational studies, Mongolian National University of Education

Abstract

Morin khuur is one of the traditional and respectful musical instruments for Mongolians and in recent years, it has been developing rapidly in Inner Mongolia. The number of students who learn the Morin khuur music is increasing, and at present time, there is a need to do research on the professional development of Morin khuur teachers and to finalize the conclusion. We collected data from 60 teachers by using questionnaire method. We have to argue in order to define the professional development of teacher from many sides and emphasized the general status of Morin khuur teacher and as well as the positive and negative factors influencing on their professional development and its elements, current situation and chances to develop in the future and how to organize trainings, seminars, competitions and conferences for them to improve their professional development. The findings show that the professional development level of Morin khuur teachers is intermediate, and it is necessary to organize professional development trainings for them, to increase leader's support, financial resource and to manage their workload impact on the professional development. Also, in the future, there are some interests that are to develop the professional skills of teachers, improve the teaching skills and learn playing many tones.

Keywords

Teacher development, Learning, Development level, Professional skills, Problems, Knowledge and Needs

* Corresponding author: mdaorigele2019@qq.com